



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/61

Улаанбаатар хот

Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ
арга хэмжээ зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9.4.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоолоор батлагдсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журам”-ын 2.4.6, 5.1.5, 5.1.6, 5.3.5, 5.3.6, 5.3.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/348 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж зам, талбай, орон сууц болон хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах таатай орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ, зохион байгуулсугай.

2. Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Тус аянд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодыг бүрэн хамруулж ажиллахыг хороодын Засаг дарга нарт, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг доголдуулахгүй байхаар дотооддоо зохион байгуулалт хийж байгууллагын орчны 50 метр газрын цэвэрлэгээг чанар үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

4. Дүүргийн 150,268м² нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн хог хаягдлын цэвэрлэгээг хийх ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Багахангай тохижилт ОНӨААТҮГ (Б.Гэрэлмаа)-т, гэрэлтүүлгийн шонг засварлах, тагжуулах, шатсан гэрлүүдийг солих, цэвэрлэгээ үйлчилгээний явцад Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ыг усаар хангах, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг ариутгах ажлыг чанар, үр дүнтэй зохион байгуулахыг Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ (Ч.Батхуяг)-т тус тус үүрэг болгосугай.

5. Их цэвэрлэгээний арга хэмжээг иргэд олон нийтэд сурталчилж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т, мэдээ тайлан нэгтгэх, танилцуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т нэгдсэн удирдлагаар хангаж, цэвэрлэгээний явцад хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны 04 дүгээр сарын 08 ны өдрийн
1764 дугаар захирамжийн хавсралт



ХАВРЫН БҮХ НИЙТИЙН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЯНЫ УДИРДАМЖ

НЭГ.ЗОРИЛГО

1.1.Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, гуу жалга, үерийн далан шуудуунд үүссэн хог хаягдлыг цэвэрлэх, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил талбайд хуримтлагдсан хог хаягдлыг ачиж, тээвэрлэх, шон дээр наасан зарлал наалтыг хуулах, гэрлийн шон, нийтийн эзэмшлийн эд хогшил, хөшөө дурсгал, хогийн сав, сандал, хайс, хашлага, мод бут, зам талбайг угааж цэвэрлэх, ААНБ-уудын хаяг хаягийн байгууламжуудыг угаах, өнгийг сэргээх зэрэг чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудыг цэвэрлэгээний үйл ажиллагаанд идэвхжүүлэн оролцуулахад энэхүү удирдамжийн зорилго оршино.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

2.1.Дүүргийн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, СӨХ-д, худалдаа, үйлчилгээний байгууллагууд.

ГУРАВ. ХУГАЦАА

3.1. Хэрэгжүүлэх хугацаа:

- Их цэвэрлэгээний өдрүүдийн үргэлжлэх хугацаа: 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрөөс 04 дүгээр сарын 19-ны өдрийг хүртэл зохион байгуулна.
- Нэгдсэн цэвэрлэгээний өдөр: 2024 оны 04 дүгээр сарын 11, 12-ны өдрүүдэд 13.00-17.00 цагийн хооронд аж ахуйн нэгж байгууллагууд орчны хог хаягдлын цэвэрлэгээ болон ногоон байгууламжийн хайс хашлагыг угаах, 2024 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр орон сууц, гэр хорооллын айл өрх, иргэд байр, хашааны орчныхоо цэвэрлэгээг зохион байгуулна.
- 2024 оны 04 дүгээр сарын 18, 19-ны өдрүүдэд 14.00-17.00 хооронд хороодоос оноож хуваарилсан талбайд түүвэр цэвэрлэгээ хийнэ.

ДӨРӨВ. АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1.Дүүргийн Засаг даргын тамгын газар нь хороодын ажлын албаны цэвэрлэгээний ажлын зохион байгуулалт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Шаардлагатай тохиолдолд Засаг даргын харьяа болон бусад байгууллагуудаас татан оролцуулж болно.

ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

5.1. Аж ахуйн нэгж, байгууллагууд орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх, угааж, чийгшүүлэх, хайс хашлага, хогийн сав, гадна фассад, хаяг, хаягийн байгууламж, үүд довжоог угааж өнгө үзэмжийг сэргээх

5.2. Гудамж, зам талбайн хог хаягдал, ногоон байгууламжийн шар өвс, хатсан шарилж ургамлыг цэвэрлэж ачуулах

5.3. Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын ачилт, цуглуулалтыг эрчимжүүлэх

5.4. Гудамж талбайн үүсмэл хогийн цэгүүдийг ачиж цэвэрлэх

5.5. Сандал, хогийн сав, хайс хашлага, замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлгийн шон, хөшөө баримлыг угаах, засварлах

5.6. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулсан өнгө үзэмжгүй хаяг, мэдээллийн байгууламжуудыг буулгах, өнгө үзэмжийг сэргээж засварлах

ЗУРГАА. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АРГА ХЭМЖЭЭ

6.1 Хороодын ажлын алба аж ахуйн нэгж байгууллагуудыг бүх нийтийн их цэвэрлэгээнд бүрэн хамруулж оролцоог хангах бөгөөд гэр хорооллын айл өрхийн орчны 50м хүртэл газрын цэвэрлэгээ субботник зохион байгуулж ажиллана.

6.2 Хороод их цэвэрлэгээний зохион байгуулалтын хүрээнд цэвэрлэгээ хийсэн иргэн, ААНБ-ын талаар мэдээллийн хэрэгслээр сурталчилж, иргэн, ААНБ-ыг уриалах тэдэнд сэдэл өгөх ажлыг зохион байгуулна.

6.3 Аж ахуйн нэгж байгууллагууд орчныхоо хог хаягдлыг цэвэрлэж, байгууллагын хана, фассад, цонх, хаяг, хаягийн байгууламж, сандал, хогийн сав, үүд довжоо, хамаарал бүхий нийтийн талбайг хөөстэй угаах, засварлах, гадна талбайгаа усалж чийгшүүлэх ажлыг хийнэ.

6.4 Багахангай тохижилт ОНӨААТҮГ нь хог тээвэрлэлтийг эрчимжүүлж хариуцсан бүсийн цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг шуурхай тээвэрлэх, зам талбайг хөөстэй чийгтэй цэвэрлэхээс гадна, хайс хашлага, хогийн сав, сандал, авто замын тэмдэг тэмдэглэгээг угаах, усан сан, хөшөө баримлыг угаах ажлуудыг тус тус зохион байгуулна.

6.5 Багахангай гэрэлтүүлэг ногоон байгууламж ОНӨААТҮГ нь гэрэлтүүлгийн шонг засварлах, тагжуулах, шатсан гэрлүүдийг солих, зарлал наалтыг хуулах, шонг угааж өнгийг сэргээх, хариуцсан талбайн ногоон байгууламжийг бүрэн цэвэрлэх, шонг тороосыг угааж цэвэрлэх болон нийтийн эзэмшлийн гудамж зам талбайг нэгдсэн байдлаар мананцраар ариутгах зэрэг зохион байгуулалтын ажил хийж гүйцэтгэнэ.

6.5 Сууц өмчлөгчдийн холбоо (Хангай өргөө СӨХ), (Баян хангай СӨХ), (Их хангай СӨХ) орчны 50м хүртэлх газарт иргэдийг татан оролцууж хайс хашлага, хогийн сав, сандалыг хөөстэй угааж талбайг цэвэрлэн чийгшүүлнэ.

6.6 Төмөр зам дагуух хог хаягдлыг УБТЗ ХНН-ээс цэвэрлэнэ.

6.7 Дүүргийн ЗДТГ цэвэрлэгээний ажилд хяналт тавьж, цэвэрлэгээнд оролцоогүй, зөрчил гаргасан иргэн хуулийн этгээдэд хариуцлага тооцож ажиллана.

ДОЛОО. ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН МЭДЭЭГ ТАЙЛАГНАХ

7.1 Цэвэрлэгээний ажлын явц болон тайланг ААНБ-ууд 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 16:00 цагт удирдамжид заагдсан чиглэлийн дагуу ажилласан арга хэмжээний талаарх илтгэх хуудас бичиж (А4 хэмжээтэй 1 хуудас байна), харьцуулсан фото зургийн хамт ЗДТГ-ын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Батхуяг)-т DOCX форматаар bbatnacag@gmail.com цахим хаягаар илгээнэ.

7.2 ЗДТГ-ын ТХҮХ эцсийн тайланг нэгтгэж Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 19:00 цагаас өмнө хүргүүлнэ.